| 2108                  | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 20465500.00           | 20465500.00   |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15410000.00           | 15410000.00   |
| 210802                | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 1620000.00            | 1620000.00    |
| 210803                | Даатгалын үйлчилгээ  | 374400.00             | 374400.00     |

Булган аймгийн Рашаант сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|               |  |               |                  |
|---------------|--|---------------|------------------|
| 210804        | Тээврийн хэрэгслийн татвар                               | 361100.00     | 361100.00        |
| 210806        | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                          | 2700000.00    | 2700000.00       |
| <b>2109</b>   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                   | 94899900.00   | 95228700.00      |
| 210901        | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 75840300.00   | 76169100.00      |
| 210902        | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                        | 19059600.00   | 19059600.00      |
| <b>213</b>    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  | 131665800.00  | 103141510.00     |
| <b>2131</b>   | <b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>                   | 81387000.00   | 70447000.00      |
| 213101        | Засгийн газрын дотоод шилжүүлэг                          | 81387000.00   | 70447000.00      |
| <b>2132</b>   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                            | 50278800.00   | 32694510.00      |
| 213205        | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                 | 36889800.00   | 19305510.00      |
| 213206        | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт            | 9889000.00    | 9889000.00       |
| 213207        | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж      | 3500000.00    | 3500000.00       |
| <b>23</b>     | <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>        | 145000000.00  | 57400000.00      |
| 230001        | Эргэж төлөгдөх зээл                                      | 145000000.00  | 57400000.00      |
|               | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    | 3061156500.00 | 2780365915.39    |
| <b>1310</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                           | 1783159500.00 | 1649888148.00    |
| 131007        | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих                 | 1783159500.00 | 1,649,888,148.00 |
| <b>1320</b>   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                    | 1039151600.00 | 1027881255.39    |
| 132001        | Орон нутгийн төсвөөс                                     | 974611600.00  | 971012259.39     |
| 132007        | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих                  | 64540000.00   | 56868996.00      |
| <b>1340</b>   | <b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>      | 32100000.00   | 32100000.00      |
| 134001        | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих                     |               |                  |
| 134002        | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих                | 32100000.00   | 32100000.00      |
| 134003        | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт  |               |                  |
| <b>120004</b> | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>             | 206745400.00  | 70496512.00      |
| 1200041       | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                | 99951300.00   | 70496512.00      |
| 1200043       | Урьд оны үлдэгдлээс санхүүжих                            | 106794100.00  |                  |
| <b>4</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  |               | 58893451.00      |
| <b>5</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b> |               | 36888581.00      |
| <b>6</b>      | <b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>                  |               |                  |
| <b>61</b>     | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                                  | 6.00          | 6.00             |
| 610001        | Төсвийн байгууллага                                      | 6.00          | 6.00             |
| 610002        | Төсвөөс гадуур байгууллага                               |               |                  |
| <b>62</b>     | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                                  | 143.00        | 143.00           |
| 620001        | Удирдах ажилтан  | 12.00         | 12.00            |
| 620002        | Гүйцэтгэх ажилтан  | 92.00         | 92.00            |
| 620003        | Үйлчлэх ажилтан  | 33.00         | 33.00            |
| 620004        | Гэрээт ажилтан   | 6.00          | 6.00             |
| <b>63</b>     | <b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>                | 977.00        | 977.00           |
| <b>630</b>    | <b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>         | 767.00        | 767.00           |
| 630001        | Төрийн өмчит ЕБС   | 767.00        | 767.00           |
| <b>631</b>    | <b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>          | 210.00        | 210.00           |
| 631001        | Төрийн өмчит СӨБ байгууллага                             | 210.00        | 210.00           |

|           |   |              |              |
|-----------|---|--------------|--------------|
| 631002    | Хувийн өмчит СӨБ байгууллага                                  |              |              |
| <b>65</b> | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                                    | <b>143.0</b> | <b>143.0</b> |
| 650001    | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)                            | 12.00        | 12.00        |
| 650004    | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)           | 60.00        | 60.00        |
| 650005    | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)         |              |              |
| 650006    | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 4.00         | 4.00         |
| 650007    | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) |              |              |
| 650008    | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 16.00        | 16.00        |
| 650009    | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)                    | 44.00        | 44.00        |
| 650010    | Гэрээт ажилтан  |              |              |
| 650011    | Улс төрийн албан хаагч (УТ)                                   | 7.00         | 7.00         |

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код  | Үзүүлэлт  | Гүйцэтгэл           |
|-------------|---|---------------------|
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>  | <b>122164249.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>122164249.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | 121814249.00        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | 8533300.00          |
| 210101      | Үндсэн цалин  | 8533300.00          |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                           | 1066700.00          |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 725300.00           |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 85400.00            |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 68200.00            |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | 52700.00            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 135100.00           |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | 14402500.00         |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл   | 14402500.00         |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | 1500000.00          |
| 210604      | Урсгал засвар   | 1500000.00          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>   | 0.00                |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>                 | 2850500.00          |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж            | 2850500.00          |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>  | 93461249.00         |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал   | 93461249.00         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | 350000.00           |
| <b>2131</b> | <b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>  | 0.00                |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>   | 200000.00           |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал   | 200000.00           |
| <b>2133</b> | <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>  | <b>150000.00</b>    |
| 213403      | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 150000.00           |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>   | 122164249.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | 122164249.00        |

|        |   |             |
|--------|---|-------------|
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж   | 1500000.00  |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 74024849.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | 46559400.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                | 80000.00    |

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сумын Засаг дарга Б.Бат-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 09-нөөс 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном гүйцэтгэв.

Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/69 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Рашаант сумын Засаг даргын тамгын газар нь Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд, Төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, олон улсын байгууллагаас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зөв зохистой ашиглан хэрэгжүүлэх, иргэдийн оролцоо ил тод байдлыг хангах, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хүн амаа өсгөх, сум орон нутгаа хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн тодорхой үр дүнд хүрэх зорилт тавин ажиллажээ.

ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Сумын Засаг даргын Тамгын газар нь сумын ИТХ, Засаг даргын үйл ажиллагааны зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн зөвлөгөө дэмжлэгээр хангах

- Төрийн үйлчилгээг чанар хүртээмжтэй шуурхай хүргэх
- Нутгийн захиргааны байгууллагуудыг бодлогоор дэмжих, эрх зүйн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангах
- Шийдвэрийн биелэлтэд хяналт шинжилгээ хийж, ололт амжилтыг урамшуулах, алдаа дутагдлыг засаж залруулах, сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг арга зүйн зөвлөмжөөр ханган төрийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах.

Рашаант сумын Засаг даргын хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Рашаант сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4098238.7 мянган төгрөгийн 2 хувь буюу 81964.8 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг суурь үзүүлэлтийг тайлант оны үр дүнгийн тайлангийн 2 хувиар буюу 78314.5 мянган төгрөг болголоо.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 116519.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 228795.6 мянган төгрөг болж, 112276.2 мянган төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мян.төгрөг/

| Үзүүлэлт   | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт, бууралт | Хувь |
|--|----------------|-----------------|----------------|------|
| Касст байгаа бэлэн мөнгө                           |                |                 |                |      |
| Төрийн сангийн харилцах Банканд байгаа бэлэн мөнгө | 111624.6       | 228795.6        | 117171         | 100  |
| Замд яваа мөнгөн хөрөнгө                           | 4894.8         | 0               | -4894.8        |      |
| Дүн  | 116519.4       | 228795.6        | 112276.2       |      |

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 228795.6 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансанд 191907.1, орон нутгийн хөгжлийн сангийн 3269.0, сум хөгжүүлэх сангийн 25105.8, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан 8513.8 мянган төгрөг тус тус төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтын иж бүрдэл хангалтгүй 21682.0 мянган төгрөг ажил гүйлгээ гаргасан. /Эрүүл мэндийн төв/

### 3.5.2 Авлага

Авлага ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансны эхний үлдэгдэл 229842.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 265344.5 мянган төгрөг болж, 35502.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /мян.төгрөг/

| Үзүүлэлт                        | Эхний үлдэгдэл  | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---------------------------------|-----------------|-----------------|------------------------|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 0               | 4478            | 4478                   |
| Байгууллагаас авах авлага       | 0               | 8328.5          | 8328.5                 |
| Зээлийн авлага                  | 229842.1        | 252538          | 22695.9                |
| <b>Дүн</b>                      | <b>229842.1</b> | <b>265344.5</b> | <b>35502.4</b>         |

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ажиллагчидтай холбогдсон авлагын 4478.0 мянган төгрөг нь ИТХ, ЗДТГ нь улс төрийн албан хаагч буюу ИТХ-н дарга, Засаг дарга нарт төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосонтой холбоотойгоор цалингийн авлага үүссэн байна.

Байгууллагаас авах авлагын 8328.5 мянган төгрөг нь “Битачи” ХХК-тай цэцэрлэгийн хүүхдийн тоглоом худалдан авах гэрээ байгуулан төлбөрөө төлсөн боловч цар тахлын улмаас хил хаагдаж тоглоом нийлүүлэх хугацаа тодорхойгүй хугацаагаар хойшилсноос үүссэн байна. Зээлийн авлага нь сум хөгжүүлэх, ЖДҮДС -гийн авлага байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Тоглоом худалдах, худалдан авах гэрээ зөрчин бараа бүтээгдэхүүнээ хүлээн аваагүй байж санхүүжилтийг нь олгосон, авлага үүсгэсэн /Хүүхдийн цэцэрлэг/*

### 3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ эхний үлдэгдэл 302673.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 260080.2 мянган төгрөг болж, 42592.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 3 Бараа материалын үлдэгдэл /мян.төгрөг/

| Үзүүлэлт                    | Эхний үлдэгдэл  | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-----------------------------|-----------------|-----------------|------------------------|
| Эм боох материал            | 12877.7         | 7968.7          | -4909                  |
| Бичиг хэрэг                 | 232.2           | 829.8           | 597.6                  |
| Аж ахуйн материал           | 234311.2        | 205430.8        | -28880.4               |
| Сэлбэг хэрэгсэл             |                 | 1120            | 1120                   |
| Түлш, шатах тослох материал |                 | 1151.5          | 1151.5                 |
| Хүнсний материал            | 30418.4         | 3095.3          | -27323.1               |
| Бусад хангамж               | 24833.6         | 40484.1         | 15650.5                |
| <b>Дүн</b>                  | <b>302673.1</b> | <b>260080.2</b> | <b>-42592.9</b>        |

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 247918.4, хандив тусламжаар 12791.5, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр 14913.1, бусад эх үүсвэрээс 5203,3 мянган төгрөгийн бараа материалыг авч, тайлант онд 260477.3 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулж, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр 34327.3, бусад болон акталж устгасан 30572.1 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 42592.9 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Бичиг хэргийн материал өмнөх оноос 597.6, сэлбэг хэрэгсэл 1120.0, түлш шатах тослох материал 1151.5, бусад хангамжийн материал 15650.5 мянган төгрөгөөр тус тус өссөн, харин эм боох материал өмнөх оноос 4909.0, аж ахуйн материал 28880.4, хүнсний материал 27323.1 мянган төгрөгөөр тус тус буурчээ. Бараа материалын тайлант оны үлдэгдлийн 79.0 хувь нь аж ахуйн материал, 15.6 хувийг бусад хангамжийн материал, 3 хувийг эм боох материал, 1.2 хувь нь хүнсний материал байна.

Нийт бараа материалын үлдэгдлийг байгууллагаар харуулбал

Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мян.төгрөг/

| д/д | Үзүүлэлт            | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-----|---------------------|----------------|-----------------|------------------------|
| 1   | ИТХ                 | 8525.3         | 8525.3          | 0                      |
| 2   | ЗДТГ                | 43488.5        | 25024.8         | -18463.7               |
| 3   | Хүн эмнэлэг         | 36981.6        | 44911.2         | 7929.6                 |
| 4   | Цэцэрлэг            | 60617.1        | 45200.3         | -15416.8               |
| 5   | Сургууль            | 120102.5       | 112885.6        | -7216.9                |
| 6   | Соёлын төв          | 23382.9        | 23532.9         | 150                    |
| 7   | Эргэлтийн эмийн сан | 9575.3         |                 | -9575.3                |
|     | Дүн                 | 302673.2       | 260080.1        | -42593.1               |

Нийт бараа материалын 43.4 хувь буюу 112885.6 мянган төгрөгийг ЕБС, 17.4 хувь буюу 45200.3 мянган төгрөгийг СӨБ, 17.3 хувь буюу 44911.2 мянган төгрөгийг эрүүл мэндийн төв, 9.6 хувь буюу 25024.8 мянган төгрөгийг ЗДТГ, 9.0 хувь буюу 23532.9 мянган төгрөгийг соёлын төв тус тус эзэлж байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 6876375.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6814140.0 мянган төгрөг болж, 62235.1 мянган төгрөгөөр буурсан байна.~~

Үндсэн хөрөнгийн 75.0 хувийг барилга байгууламж, 9.5 хувийг машин тоног төхөөрөмж, 4.8 хувийг авто тээврийн хэрэгсэл, 2.2 хувийг тавилга эд хогшил, 1.1 хувийг бусад биет бус хөрөнгө 0.6 хувийг ном эзэлж байна.

Хүснэгт № 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мян.төгрөг/

| Үзүүлэлт                    | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-----------------------------|----------------|-----------------|------------------------|
| Барилга байгууламж          | 5074147.3      | 5111631.1       | 37483.8                |
| Авто тээврийн хэрэгсэл      | 353724.7       | 326077          | -27647.7               |
| Машин тоног төхөөрөмж       | 677745.2       | 648696.2        | -29049                 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 213286         | 150414.5        | -62871.5               |
| Бусад үндсэн хөрөнгө        | 441840.1       | 462260.1        | 20420                  |

|                              |                  |                |                 |
|------------------------------|------------------|----------------|-----------------|
| Дуусаагүй барилга байгууламж | 5000             |                | -5000           |
| Ном                          | 35338.8          | 37823.1        | 2484.3          |
| Программ хангамж             | 1505             | 3450           | 1945            |
| Бусад биет бус хөрөнгө       | 73788            | 73788          | 0               |
| <b>Дүн</b>                   | <b>6876375.1</b> | <b>6814140</b> | <b>-62235.1</b> |

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 37607.2, балансас балансад шилжүүлэн авсан 3424.9, бусад буюу элэгдлээрээ анхны үнэ нөхсөн хөрөнгийг дахин үнэ тогтоосонтой холбоотой 264102.6, үнэ төлбөргүй хандиваар авсан 38053.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн, балансас балансад шилжүүлсэн 19898.1, акталсан 84883.6, бусад буюу анхны өртгөө нөхсөн хөрөнгийг хассан 300641.1 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Хүснэгт № 6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мян.төгрөг/

| д/д | Үзүүлэлт            | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-----|---------------------|----------------|-----------------|------------------------|
| 1   | ИТХ                 | 69203.7        | 66725.3         | -2478.4                |
| 2   | ЗДТГ                | 2449332.8      | 2503162.9       | 53830.1                |
| 3   | Хүн эмнэлэг         | 820792.5       | 807080.9        | -13711.6               |
| 4   | Цэцэрлэг            | 470167.7       | 461431.7        | -8736                  |
| 5   | Сургууль            | 2365810        | 2312395.3       | -53414.7               |
| 6   | Соёлын төв          | 692036.8       | 663344.1        | -28692.7               |
| 7   | Эргэлтийн эмийн сан | 9031.7         |                 | -9031.7                |
|     | Дүн                 | 6876375.2      | 6814140.2       | -62235.0               |

Үндсэн хөрөнгийн 36.7 хувийг сумын ЗДТГ, 33.9 хувийг Ерөнхий боловсролын сургууль, 11.8 хувийг Эрүүл мэндийн төв, 6.8 хувийг хүүхдийн цэцэрлэг, 9.7 хувь нь соёлын төвийн үндсэн хөрөнгө байна.

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 3525.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 5641.7 мянган төгрөг болж, 2115.9 сая төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт                         | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------------------------------|----------------|-----------------|------------------------|
| Ажиллагчидтай холбогдсон өглөг   | 0              | 2629.9          | 2629.9                 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1825.8         | 1822.8          | -3                     |
| Байгууллагаас авах авлага        | 1700           | 371.6           | -1328.4                |
| Хүмүүст өгөх өлөг                |                | 817.4           | 817.4                  |
| <b>Дүн</b>                       | <b>3525.8</b>  | <b>5641.7</b>   | <b>2115.9</b>          |

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ажилчидтай холбогдсон өглөгийн 2314.9 мянган төгрөг нь сумын ИТХ улс төрийн албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл буруу тооцон олгосноос шалтгаалан цалин хүргэлцэхгүй өглөг үүссэн, 315.0 мянган төгрөг нь Эрүүл мэндийн төвийн өглөг тайлант онд шинээр үүссэн, бараа үйлчилгээний зардлын 1822.8 мянган төгрөгийн

өглөг нь ЗДТГ-ын өмнөх оны өглөг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж, төсөвт байгууллагын өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авах, авлага өглөг үүсгэхгүй ажиллах шаардлагатай байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6172412.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6242107.3 мянган төгрөг болж, 69694.9 мянган төгрөгөөр өссөн байна

#### Хүснэгт № 31. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

| <u>Үзүүлэлт</u>  | <u>Эхний үлдэгдэл</u>      | <u>Эцсийн үлдэгдэл</u>     | <u>Өсөлт/+, бууралт -/</u> | <u>Дүнд эзлэх хувь</u> |
|--|----------------------------|----------------------------|----------------------------|------------------------|
| <u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u> | <u>1904724.8</u>           | <u>1899781.5</u>           | <u>-4943.3</u>             | <u>30.4</u>            |
| <u>Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/</u>                                      |                            |                            | <u>0</u>                   |                        |
| <u>Хуримтлагдсан үр дүн</u>  | <u>-69194.1</u>            | <u>5672.9</u>              | <u>74867</u>               | <u>0.1</u>             |
| <u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>                                      | <u>4336881.7</u>           | <u>4336652.9</u>           | <u>-228.8</u>              | <u>69.5</u>            |
| <u>Бодлогын өөрчлөлт алдааны залруулга</u>                                   | -                          | -                          | <u>0</u>                   | -                      |
| <b><u>Дүн</u></b>  | <b><u>6,172,412.40</u></b> | <b><u>6,242,107.30</u></b> | 69,694.90                  | -                      |

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 6242107.3 мянган төгрөг болж 69694.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Үүнд:

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 4336652.9 мянган төгрөг болж 228.7 мянган төгрөгөөр буурсан нь сумын Эрүүл мэндийн төв дахин үнэлгээтэй хөрөнгө акталж түүний дахин үнэлгээ буурснаас шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 5672.9 сая төгрөг болж 74867.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5.7 Зардлын данс

Сумын ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар тогтоолоор сумын 2020 оны төсвийн жилд зарцуулах төсвийг 3061156.6 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 2802370.8 мянган төгрөг буюу 91.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### Аудитын илрүүлэлт:

- *ЕБС хичээл үйлдвэрлэлийн зардлаас 3078.0, бараа үйлчилгээний зардлаас 2000.0 мянган төгрөгийн урсгал засварын зардалд зарцуулсан,*
- *ОНХС-гаас Рашаант сумын Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 08 -ны өдрийн А/96 захирамжаар дэд хөтөлбөр гэж баталсан ч 2600.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,*
- *Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг ахмадын хүлээн авалтад зарцуулсан, /Хүүхдийн цэцэрлэг/*
- *Хүүхдийн цэцэрлэг УСНББОУС болон НБББББ-ийг зөрчин цалинг өглөг дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн,*
- *Нягтлан бодогчид 2020 оны төсөвт батлуулаагүй 1741.5 мянган төгрөгийн ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдлийг олгосон, /Хүүхдийн цэцэрлэг/*
- *ИТХ нь сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын дагуу эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байхыг зөрчсөн,*

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар тогтоолоор сумын 2020 оны төсөвт төвлөрүүлэх орлогыг 94950.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр тайлант онд 277823.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 292.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мян.төгрөг/

| Үзүүлэлт                          | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл         | Зөрүү     | Хувь  |
|-----------------------------------|-----------------|-------------------|-----------|-------|
| <b>НИЙТ ОРЛОГО</b>                | 94,950.0        | 277,823.01        | 182,873.0 | 292.6 |
| <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>            | <b>50,650.0</b> | <b>141,845.26</b> | 91,195.3  | 280.0 |
| Хувь хүний орлогын албан татвар   | <b>36,430.0</b> | <b>117,671.5</b>  | 81,241.5  | 323.0 |
| Үйл ажиллагааны орлого            | 6,000.0         | 8,397.1           | 2,397.1   | 140.0 |
| Хөрөнгийн орлого                  | 22,430.0        | 37,711.1          | 15,281.1  | 168.1 |
| Шууд бус орлого                   | 8,000.0         | 71,563.3          | 63,563.3  | 894.5 |
| Хөрөнгийн албан татвар            | <b>1,260.0</b>  | <b>1,260.0</b>    | -         | 100.0 |
| Бууны албан татвар                | 1,260.0         | 1,260.0           | -         | 100.0 |
| Бусад нийтлэг төлбөр, хураамж     | <b>9,700.0</b>  | <b>10,110.3</b>   | 410.3     | 104.2 |
| Улсын тэмдэгтийн хураамж          | 3,000.0         | 4,257.3           | 1,257.3   | 141.9 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 6,700.0         | 5,852.9           | (847.1)   | 87.4  |
| Газрын төлбөр                     | -               | <b>9,634.6</b>    | 9,634.6   |       |
| Газрын төлбөр                     | -               | 9,634.6           | 9,634.6   |       |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр   | <b>3,260.0</b>  | <b>3,168.9</b>    | (91.1)    | 97.2  |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 3,260.0         | 3,168.9           | (91.1)    | 97.2  |
| <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>        | <b>44,300.0</b> | <b>135,977.8</b>  | 91,677.8  | 306.9 |
| Нийтлэг татварын бус орлого       | <b>44,300.0</b> | <b>135,977.8</b>  | 91,677.8  | 306.9 |
| Хүүгийн орлого                    | 44,300.0        | 135,977.8         | 91,677.8  | 306.9 |

Сумын төсөвт 8 нэр төрлийн орлого оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр нийт дүнгээрээ 182873.0 мянган төгрөгөөр буюу 292.6 хувиар давж биелсэн, орлогыг нэр төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого 2397.1, шууд бус орлого 63563.3, торгуулийн орлого

91677.8 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол хог хаягдлын үйлчилгээний хураамж 847.1, ус рашааны нөөц ашигласны төлбөр 91.1 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

Дээрх орлогын биелэлтийг авч үзвэл: шууд бус орлого нь урьд оны ноосны урамшууллын мөнгө, эрдэнэс таван толгойн хувьцааны ногдол ашиг тараасны мөнгө, мөн хяналт шалгалттай холбоотой орсон орлого байна.

Торгуулийн орлого: Бэлэн бусын торгуулийн орлогын биелэлтээс шалтгаалан давж биелсэн байна.

### **Төсвийн төлөвлөлт:**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3137689.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3137689.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 76532.5 сая төгрөгөөр бууруулж 3061156.6 мянган төгрөгөөр баталсан байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх ... хөтөлбөрт зориулан 3061156.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2916156.5 сая төгрөгийг урсгал зардалд, 145000.0 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 3061156.6 мянган төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгээс 1783159.5, орон нутгийн төсвөөс 974611.6, орон нутгийн хөгжлийн сангаас 64540.0, эрүүл мэндийн даатгалын сангаас 32100.0, үндсэн үйл ажиллагааны орлогоос 99951.3, урьд оны санхүүжилтээс 106794.1 мянган төгрөгийг орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1649888.1, орон нутгийн төсвөөс 971012.3, орон нутгийн хөгжлийн сангаас 56868.9, эрүүл мэндийн даатгалын сангаас 32100.0 үйл ажиллагааны орлогоос 70496.5 нийт 2780365.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 70496.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 29454.8 мянган төгрөгөөр тасарсан нь сум хөгжүүлэх сангийн орлого 57799.5 мянган төгрөгөөр тасалснаас шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2802370.8 мянган төгрөг буюу 91.5 хувьтай байгаа нь хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотой сургууль, цэцэрлэг үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой цалингийн зардал 25244.1, ндш 10994.0, байр ашиглалт 40431.8, хоол хүнс 65286.8 шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан орон нутгийн орлогод 554191.2, улсын төсөвт 133271.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар эрүүл мэндийн төв 1500.0, Засаг даргын нөөц хөрөнгөөс 89604.9, дээд шатны төсвийн захирагчаас 27792.8, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3266.4 нийт 122164.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалингийн зардалд 8533.3, НДШ 1066.7, эм хэрэгсэлд 14402.5, урсгал засварт 1500.0, бусдаар гүйцэтгүүлэх зардалд 2850.5, бараа үйлчилгээний бусад зардалд 93461.2, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 150.0 нийт 122014.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 150.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 140 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 554.0 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |       | Биелэлт |       | Биелэгдээгүй |     | /сая төгрөг/<br>Хэрэгжилтийн хувь |
|-----------------|---------------------|-------|---------|-------|--------------|-----|-----------------------------------|
|                 | Тоо                 | Дүн   | Тоо     | Дүн   | Тоо          | Дүн | Хувь                              |
| Төлбөрийн акт   |                     |       |         |       |              |     |                                   |
| Албан шаардлага |                     |       |         |       |              |     |                                   |
| Зөвлөмж         | 3                   | 554.0 | 3       | 554.0 |              |     | 100                               |
| Нийт            |                     |       |         |       |              |     |                                   |

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 1 дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 112082.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүллээ.

Төвлөрүүлсэн захирагчид 112082.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 203317.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 1839.5 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 142245.6 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 59232.6 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлж, алдаа зөрчил өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд орлогын биелэлт их хэмжээгээр давсан орлогын төлөвлөлтийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

## **4.1 Орлогын данстай холбоотой асуудал**

4.1.1 Илрүүлэлт: Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээрээ 182873.0 мянган төгрөгөөр буюу 292.6 хувиар давж биелсэн, орлогыг нэр төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого 2397.1, шууд бус орлого 63563.3, торгуулийн орлого 91677.8 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол хог хаягдлын үйлчилгээний хураамж 847.1, ус рашааны нөөц ашигласны төлбөр 91.1 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

Энэ нь "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, 41.2.1-д хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх заалтыг хэрэгжүүлээгүй зөрчсөн байна.

4.1.2 Эрсдэл: Орлогын төлөвлөгөө биелэхгүй, боломжит орлогууд төвлөхгүй үлдсэн байх магадлалтай, санхүүжилтийн эх үүсвэр дутагдсанаас өглөг нэмэгдэх, хөтөлбөр арга хэмжээ хэрэгжихгүй байх.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль. 41 дүгээр зүйл. 41.2.1-д хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх, Төсвийн орлогын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Асуудлын бүртгэлээр танилцуулж зөвшөөрсөн.

## **4.2 Авлага, өглөгтэй холбоотой асуудал**

4.2.1 Илрүүлэлт: Сумын төсөвт байгууллагууд Тайлант онд ИТХ 1711.2, ЗДТГ 1937.3, Цэцэрлэг 8011.7, соёлын төв 317.8 мянган төгрөгийн авлага, ИТХ 3132.2, ЗДТГ өмнөх оны өглөг 1822.8, эрүүл мэндийн төв 686.6 мянган төгрөгийн авлага, өглөг үүсгэсэн байна. Мөн сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдлийн 49.5 хувь 111144.2 мянган төгрөг хугацаа хэтрэлттэй, эргэн төлөлтийн байдал хангалтгүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг зөрчсөн байна.

4.2.2 Эрсдэл: Авлага, өглөгийг тухай бүр барагдуулаагүй байх.

4.2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж оны эцэст авлага, өглөггүй ажиллах, сум хөгжүүлэх сангийн зээлийг хугацаандаа төлөөгүй иргэдийн асуудлыг хууль хяналтыг байгууллагад шилжүүлж, авлагыг бүрэн барагдуулж, төсвийг хохиролгүй болгох.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Асуудлын бүртгэлээр танилцуулж зөвшөөрсөн.

## **4.3 Дотоод хяналттай холбоотой асуудал**

4.3.1 Илрүүлэлт: Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 203317.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 1839.5 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 142245.6 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 59232.6 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлж, алдаа зөрчил өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, сангийн сайдын 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

4.3.2 Эрсдэл: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас

4.3.3 Өгсөн зөвлөмж: Сумын төсөвт байгууллагуудын төсвийн захирагч, нягтлан бодогч нар, санхүүгийн албаны даргын сахилга хариуцлагыг дээшлүүлж, хууль, журмыг мөрдөж,

санхүүгийн тайланг алдаагүй үнэн зөв илэрхийлж, өмнөх аудитаар гарсан алдааг давтан гаргахгүй ажиллах.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Асуудлын бүртгэлээр танилцуулж зөвшөөрсөн.

#### **4.4 Шилэн данстай холбоотой асуудал**

4.4.1 Илрүүлэлт: Тус байгууллагын 2020 онд Шилэн дансны цахим хуудсанд 151 мэдээллээс 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

4.4.2 Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх, удирдлага харилцагч нар мэдээллээр хангагдахгүй байх.

4.4.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д заалтыг хэрэгжүүлэн ажиллаж, хуульд заасан мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлж хэвших.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Асуудлын бүртгэлээр танилцуулж зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### **АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

#### **БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ